ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 10 өдөр Дугаар А/59 Мөрөн сум

Ой хээрийн түймрээс урьдчилан
сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59.1.21, Ой хээрийн түймрээс хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Албан газар, Аж ахуйн нэгж, ард иргэдэд хавар намрын хуурайшилтын улиралд ой хээрийн болон объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар ухуулга сурталчилгааны ажлыг гар утас, хэвлэл мэдээллийн бүх хэрэгсэл ашиглан дамжуулж, сэрэмжлүүлэг тарааж баталгаа гаргуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Намжилноров), Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Ш.Баасандорж), Байгаль хамгаалагч (Б.Бямбадорж), бүх багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2.Ой хээрийн болон объектод түймэр гарсан үед түймэр унтраах хүн хүч, техникийн томилгоо, хүнс шатахуунаар хангах хэлцэл, сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг багаж төхөөрөмжөөр хангах, нөхөн бүрдүүлж ажиллахыг сумын Мэргэжлийн ангийн дарга, (Б.Мягмаржав), хангалт хариуцсан ажилтан (Д.Эрдэнэцэцэг) нарт үүрэг болгосугай.

3.Багийн нутаг дэвсгэрт түймэр гарч болзошгүй газруудын маршрут гаргаж морьтой болон мотоциклтой байнгын эргүүл томилж, түймэр гарсан үед сумаас хүн хүч техник хэрэгсэл иртэл багаас ажиллах хүмүүсийг томилж, багаж тоног төхөөрөмжөөр хангаж ажиллуулахыг бүх багийн Засаг дарга нарт даалгасугай.

4.Сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, түймрийн 1,2,3 дугаар ээлжийн бэлэн байдлыг тухай бүр нь шалгаж, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн галын булангийн иж бүрдэл, цахилгааны аюулгүй байдлыг үзэж шалган үүрэг даалгавар өгч ажиллахыг Шуурхай штабын дарга, Мэргэжлийн ангийн дарга (Б.Мягмаржав)-д үүрэг болгосугай.

5.Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээ тайлан, илтгэх хуудсыг удирдах дээд байгууллагад явуулж, түймрийн хохирлын акт тогтоох аргачлалыг холбогдох албан хаагч нарт бүрэн эзэмшүүлсэн байхыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Намжилноров)-т үүрэг болгосугай.

6.Ой хээрийн түймэртэй тэмцэх 1,2,3 дугаар бүлгийн томилгоог хавсралтаар баталсугай.

7.Энэхүү захирамжийн биелэлтийг хагас бүтэн жилээр гаргаж сумын Засаг даргын зөвлөлийн хуралд тайлагнаж байхыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Намжилноров)-т даалгасугай.

8. Уг захирамж хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн үеэс 2022 оны 04 дүгээр сарын 06-ний өдрийн А/48 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА Ц.БАТЦООЖ

C:\My Documents\ZAXIRAMZI.doc

0340020 59

-ны өдрийн А/59 тоот захирамжийн хавсралт

ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ
БҮЛГИЙН ТОМИЛГОО

## ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ 1-Р ЭЭЛЖИЙН ТОМИЛГОО

| № | Овог нэр | Томилгоо | Утасны дугаар |
|---|---|---|---|
| 1 | Норовсүрэн Намжилноров | Бүлгийн дарга | 98615160 |
| 2 | Дугарсүрэн Батгэрэл | Жолооч | 88527039 |
| 3 | Гончигдорж Загдцэсэм | Жолооч | 98902028 |
| 4 | Г.Сэргэлэнбаатар | Гишүүн | 98300216 |
| 5 | Баярсайхан Алтангэрэл | Гишүүн | 99226465 |
| 6 | Түвшинтөр Гүржав | Гишүүн | 98117664 |
| 7 | Энхболд Балчиндорж | Гишүүн | 98565698 |
| 8 | Наранболд Энх-Эрдэнэ | Гишүүн | 90920119 |
| 9 | Бямбаа Энхтөр | Гишүүн | 94525297 |
| 10 | Жаргал Гантулга | Гишүүн | 98997550 |
| 11 | Батмөнх Төртогтох | Гишүүн | 96669990 |

# ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ 2-Р ЭЭЛЖИЙН ТОМИЛГОО

| № | Овог нэр | Томилгоо | |
|---|---|---|---|
| 1 | Бат-Эрдэнэ Мягмаржав | Булгийн дарга | 99541992 |
| 2 | Ядамсүрэн Энхбаатар | Жолооч | 93144164 |
| 3 | Сонин-Алдар Энхсүх | Жолооч | 91450224 |
| 4 | Пүрэвхүү Сугар | Гишүүн | 95007477 |
| 5 | Батгэрэл Бямбадорж | Гишүүн | 89406176 |
| 6 | Батгэрэл Лхагвасүрэн | Гишүүн | 95717163 |
| 7 | Бат-Эрдэнэ Мягмаржав | Гишүүн | 99541992 |
| 8 | Наранбаатар Амармөрөн | Гишүүн | 95544884 |
| 9 | Наранцэцэг Пүрэвцэрэн | Гишүүн | 98474950 |
| 10 | Дамдин Отгонбаяр | Гишүүн | 98994055 |

# ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ 3-Р ЭЭЛЖИЙН ТОМИЛГОО

| № | Овог нэр | Томилгоо | |
|---|---|---|---|
| 1 | Шуурайдагва Баасандорж | Бүлгийн дарга | 95000137 |
| 2 | Жаргал Алтансүх | Жолооч | 99929900 |
| 3 | Наранбаатар Лхагва-Очир | Жолооч | 99560222 |
| 4 | Самбуужав Наранхүү | Гишүүн | 88381884 |
| 5 | Дамдинсүрэн Бат-Эрдэнэ | Гишүүн | 89434980 |
| 6 | Сэдэд Түвшинтөр | Гишүүн | 98164382 |
| 7 | Сүмбэнбаатар Сүхчулуун | Гишүүн | 86133974 |
| 8 | Пехутан Баярмагнай | Гишүүн | 88726040 |
| 9 | Даваасүрэн Дащдорж | Гишүүн | 98878440 |
| 10 | Бадамсад Баяр-Энх | Гишүүн | 80023602 |

71